



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ОРОН СУУЦНЫ ДЭД БҮТЦИЙН ГАЗАР**

Нийслэлийн засаг захиргааны IV байр, Бага тойруу-15,
Самбууний гудамж, 4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,

Улаанбаатар хот, 14191

Утас: 7011-0733

E-mail: info@ger.ub.gov.mn

<http://www.ger.ub.gov.mn>

2019.09.06 № *02/661*

танай _____ -ны № _____ -т

Г Тодруулга хүргүүлэх тухай Г

Нийслэлийн Орон сууцны дэд бүтцийн газраас зарласан Өвөлжилтийн бэлтгэл хангах ажил, Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны Туул тосгоны 14 дүгээр халаалтын зуухны сүлжээний 2 дугаар хэлхээний насосны хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг гүйцэтгэх тухай тендерийн үнийн санал авах урилгыг 2019 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн "Өдрийн сонин"-ны №177 (6278) дугаарын 8 дугаар нүүрт нийтэлсэн.

Тус ажлыг tender.gov.mn Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд 2019 оны 08 дугаар сарын 30-ны өдөр худалдан авах ажиллагааны журам өөрчлөгдөн нээлттэй тендер шалгаруулалтын журмаар шалгаруулахаар байршуулсан тул тендерийн баримт бичигт тусгасан хүлээн авах, нээлт хийх хугацааг өөрчилж байна.

1. НХААГ/201908770 дугаартай тендерийн үнийн саналыг 2019 оны 09 дүгээр сарын 9-ний өдрийн 10 цаг 00 минутаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийн үнийн саналыг 2019 оны 09 дүгээр сарын 9-ний өдрийн 10 цаг 30 минут-т нээнэ гэснийг 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 11 цаг 00 минутаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 11 цаг 30 минут-т нээнэ гэж тендерийн баримт бичигт залруулж байна.

Тендерийн баримт бичгийн өөрчлөлт орсон тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтийн хуулбарыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 2 хуудастай.

ДАРГА

Ч.БАТБИЛЭГ



114050000367

ТӨӨЗ 20.1	Тендер хүчинтэй байх хугацаа нь тендерийг нээнээс хойш 30 хоногийн туршид хүчинтэй байна.
Г. Тендер ирүүлэх	
ТӨӨЗ 22.3 (б)	<p>Тендер хүлээн авах этгээд: Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn хаягаар өөрийн аж ахуйн нэгжийн тоон гарын үсгийг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ.</p> <p>Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50,000 /тавин мянга/ төгрөгийг www.tender.gov.mn-ээр банкны цахим телбөр тооцооны системийг ашиглан төлнө.</p>
ТӨӨЗ 22.3 (в)	<p>Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн Adobe PDF хэлбэрт шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлнэ. Нэр, дугаарыг гаргацтай тэмдэглэнэ:</p> <p>Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй “Туул тосгоны 14 дүгээр халаалтын зуухны сүлжээний 2 дугаар хэлхээний насосны хүчин чадлыг нэмэгдүүлэх /Хан-Уул дүүрэг, 13 дугаар хороо/-ны ажил</p> <p>Тендер шалгаруулалтын дугаар: НОСДБГ-2019/02</p>
ТӨӨЗ 22.6	Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
ТӨӨЗ 23.1	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр</p> <p>Цаг: 11 цаг 00 минут</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй. Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.</p>
Д. Тендер нээх, үнэлэх	
ТӨӨЗ 26.1	<p>Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд:</p> <p>Байшин, гудамжны нэр: 4 дүгээр хороо, Бага тойруу-15, Нийслэлийн Засаг захиргааны IV байр.</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 7 дугаар давхар, 705 тоот өрөө.</p> <p>Аймаг, хот: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг.</p> <p>Улс: Монгол Улс.</p> <p>Тендерийн нээлт хийх огноо, цаг нь:</p> <p>Огноо: 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр.</p> <p>Цаг: 11 цаг 30 минут.</p>
ТӨӨЗ 31.1 (з)	Үнэлгээнд ашиглах нэмэлт шалгуурууд.

	<ol style="list-style-type: none"> 1. Зураг төсөл боловсруулах байгууллага нь улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл, зураг төсөл боловсруулах гэрээний эхээс хийсэн өнгөт хуулбарыг ирүүлнэ. 2. Зураг төсөл боловсруулах байгууллага нь эскиз зураг, төсвийг боловсруулж тендерт ирүүлэх ба тендерт шалгарсан тохиолдолд экспертизээр баталгаажуулж, ажлын зураг төсөл боловсруулах явцад захиалагч байгууллагатай зөвшилцөх, магадлал хийлгэх ажлыг 14 хоногийн дотор гүйцэтгэж захиалагчид хүлээлгэн өгсний дараа барилга угсралтын ажлыг гүйцэтгэж эхэлнэ. <p>Зураг төсөл боловсруулах байгууллага нь дээрх шалгууруудын аль нэгийг хангаагүй нөхцөлд тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
--	---